Мөнгөний бодлого: Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн үнэлгээ, тогтвортой санхүүжилт

2021 оны 9-р сарын 6

Шар түйрэн, БНХАУ ба Монгол улсаас дэгдэж буй, *Эх сурвалж: NASA. April 2001, https://svs.gsfc.nasa.gov/2956*

9 тэрбум ам.доллар

Өмнөд Солонгосын эдийн засагт учруулж буй хохирол

Уур амьсгалын өөрчлөлт – Санхүүгийн салбарын эрсдэл

Нийт бэлчээрийн 65 хувь талхлагдсан

Photo: Daesung Lee



Нийт CO_2 ялгарлаар
79-т

Нэг хүнд ногдох CO_2 ялгарлаар
44-т

Ган зуд, нийгэм дэх сөрөг үр дагавар

1999-2000 оны ган зудын хохирол ₮333 тэрбум (нийт малын 10.4% хорогдсон)
2009-2010 оны зудын хохирол ₮527 тэрбум (23%)

Эх сурвалж: ХХААХҮЯ, ҮСХ, and NPR 2019

СОРИЛТ: НИЙГМИЙН СӨРӨГ ҮР ДАГАВАР, 1988-2018

"Нийтийн өмчийн эмгэнэл"





Хөдөөгөөс хот уруу шилжих урсгал | CO2, агаарын бохирдол | Хөрсний бохирдол

Усны бохирдол | Халдварт өвчин | Ажилгүйдэл | Ядуурал

Эх сурвалж: NPR 2019

УАӨ-н эсрэг улс орнуудын амлалт



- НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
- Парисын хэлэлцээр, 2015

Монгол Улсын ҮТХН-ийн дагуу бууруулахаар зорьж буй хүлэмжийн хийн хувь, *BAU-тай харьцуулахад*

22.7%

“

Due to its unique geography, Mongolia has warmed three times faster than the rest of the world (1901-2015) and 80 percent of the country is defined as highly vulnerable to climate change...

... Over the last ten years, external and environmental vulnerabilities have risen in Mongolia. As a result, Mongolia is less prepared to deal with shocks going forward, whether it is a sharp fall in global growth or a repeat of the extreme climate events that are occurring with increasing frequency. Addressing these concerns will take time and sustained policy effort. Nonetheless, identifying and understanding these challenges is central to securing sustainable growth and macroeconomic stability going forward.

”

Source: IMF Country Report no. 19/297: Mongolia 2019 Article IV consultation, September 2019

Тогтвортой санхүү

Текстилийн салбарт баримтлах ногоон зээлийн шалгуур

Зорилго

Ногоон зээлийн шалгуур нь аливаа санхүүгийн байгууллага Монгол Улсын текстилийн салбарын ногоон төсөлд санхүүжилт олгох, төслийг үнэлэхэд ашиглах суурь шалгуур, ангиллыг тодорхойлсон баримт бичиг юм.

Явцын болон эцсийн материалд санал авахаар хүргүүлсэн байгууллагууд (80 гаруй байгууллага): Ноос ноолуурын төсөл, санаачлага хэрэгжүүлэгч байгууллагууд (AVSF, SDC, SFA, WCS, UNDP MSCP, TNC), төрийн агентлагууд, яамд Монголбанк, ЭХЗХ, Усны газар, УСУГ, БОАЖЯ-ны ИЦТХэлтэс, ХХААХҮЯ, Сангийн Яам), бүх арилжааны банкууд, олон улсын байгууллагууд (УАНС, ОУСК, Каритас), төрийн бус байгууллагууд (Хөгжлийн Шийдэл ТББ), холбоод (Монголын Ноос Ноолуурын Холбоо, Монголын бэлчээр ашиглагчдын холбоо), ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд г.м

Шалгуур боловсруулт, санал авах үе шат

2020/08
Төслийн менежер шалгуурыг боловсруулж эхэлсэн – Суурь судалгаа

2020/10-12
Инженерүүдтэй уулзалт хийж, шалгуурыг драфтлав

2020/01
Үйлдвэрүүдэд танилцуулах, санал авах цахим уулзалт

2021/01
ToC Банкны зөвлөлийн уулзалтад танилцуулав

2021/1,2
Оролцогч талууд болох төр, олон улс, хувийн хэвшил, ТББ-уудрүү саналыг хүргүүлэв.

2021/03
Шалгуурын шинэчилсэн тайланд сүүлийн саналыг авч эцэслэв.

Текстилийн салбарт баримтлах ногоон зээлийн шалгуур

Шалгуур

Ангилал	Ерөнхий ногоон зориулалт	Шалгуур	Баталгаажуулалт
Эрчим хүчний хэмнэлт	• Эрчим хүчний хэмнэлт (ЭХХ)-тэй тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах • Барилгын дулаалгын ажил хийх	Текстилийн салбарын ногоон төслүүдэд зээл олгохоос өмнө тухайн төсөл, зээлийн зориулалт нь доорх техникийн шалгууруудыг хангаж буй эсэхийг үнэлж баталгаажуулна. Баталгаажуулалтыг хийхдээ доорх эх сурвалж, баримт бичгүүдийг ашиглаж болно. • Зээлээр авахаар төлөвлөж буй тоног төхөөрөмж, түүхий эд, барилга байгууламжийн ногоон/тогтвортой шошго, гэрчилгээ, стандарт • Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, гэрчилгээ • ЕСБХБ-ны Ногоон технологийн каталог • Хөндлөнгийн аудиторын үнэлгээ, дүгнэлт/шинжилгээ • Бусад судалгаа, тооцоолол, баталгаажуулалт	Гэрчилгээ, хөндлөнгийн баталгаажуулалт эсвэл аудиторын урьдчилсан дүгнэлт зэрэг багтана.
Сэргээгдэх эрчим хүч (СЭХ)	• Бага оврын СЭХ шийдлүүд суурилуулах • Том хэмжээний СЭХ үүсгүүр суурилуулах буюу барих		
Усны хэрэглээ	• Цэвэр усны хэмнэлттэй машин, тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах • Бохир ус цэвэрлэх машин, тоног төхөөрөмж худалдан авах		
Химийн бодис зохистой хэрэглээ	• Ногоон шаардлага хангасан химийн бодис худалдан авах • Химийн бодисын агуулах, лаборатори, станц барих		
Хог хаягдлын менежмент	• Хатуу хог хаягдлыг дахин ашиглах, дахивар болгох, сав суулга худалдан авах • Дахин боловсруулсан эсвэл байгальд хоргүй материалаар хийгдсэн уут, сав, баглаа боодол, хайрцаг худалдан авах		
ЭХХ, Ногоон барилга	• ЭХХ-тэй барилга барих • Ногоон барилга барих		
Карбон бага буюу цэвэр тээвэр	• Үйлдвэрийн хэрэгцээний тээврийн хэрэгслийг цахилгаан, хайбрид машин болгох		
Тогтвортой түүхий эд	• Тогтвортой аргаар бэлтгэсэн, чанарын гэрчилгээтэй түүхий эдийг худалдан авах • Бүтээгдэхүүн, түүхий эдийн мөшгөх системийг бий болгох, хөгжүүлэх		

- Техникийн хорооноос талуудын санал, технологийн хөгжил, зах зээлийн хэрэгцээ, бодлогын орчны өөрчлөлттэй уялдуулан, хоёр жилд нэг удаа шинэчилнэ.

Мөнгөний бодлогод оруулах санал

Чиглэл: Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд

Зорилт:
Тогтвортой санхүүжилтийн үндэсний стратеги боловсруулж, санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийн зорилт, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ба дасан зохицох үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах чадавх, бодлогын орчныг бүрдүүлнэ.

Стратеги:

- Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн салбарт мөрдүүлэх, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах зорилго бүхий төр, хувийн хэвшил ба олон талт хамтын ажиллагаанд суурилсан тогтвортой санхүүжилтийн урт хугацаанд баримтлах үндэсний цогц стратегийг батлах
- Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан зорилтуудтай уялдуулан Тогтвортой хөгжлийн зорилтуудын (SDG) санхүүжилтийн таксономи боловсруулж нэвтрүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүрэгт уур амьсгалын эрсдэлийг санхүүгийн салбарт тооцох зорилт нэмж оруулах
- Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зургийг салбарын бодлого, олон улсын чиг хандлага, сайн туршлагатай уялдуулан шинэчлэн сайжруулж **Үндэсний тогтвортой санхүүжилтийн стратеги** боловсруулна.
- Банкинд байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх журам баталж, энэ хүрээнд БОН-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, тогтвортой тайлагналтай холбогдох аргачлалыг нэвтрүүлнэ.
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд эрчим хүчний хэмнэлттэй болон ногоон барилгыг санхүүжүүлэх тухай заалт, аргачлалыг нэмж оруулна.
- Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв Банкны зүгээс авч хэрэгжүүлэх боломж бүхий хөшүүргийн арга хэрэгслүүдийг судалж, нэвтрүүлнэ.
- Үндэсний ногоон таксономийг өргөжүүлэн тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бүхий SDG санхүүжилтийн таксономи боловсруулна.
- Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, уг чиглэлд хийгдэх судалгаа ба эрдэмтэн судлаачдын тоог нэмэгдүүлэх зорилготой чадавх бүрдүүлэх аян зохион байгуулна.

Үндэсний тогтвортой санхүүжилтийн стратеги

Удирдлага, зохион байгуулалт:

СТБЗ, Сангийн яам, Монголбанк, СЗХ, БОАЖЯ, МХБ, МБХ, НҮБХХ

Зорилго:

Санхүүгийн салбарын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах, олон талт оролцогчдыг хамарсан, нэгдсэн стратеги, чиглэлийг тодорхойлох

1. БОНЗ-ын эрсдэлийн удирдлага

- БОНЗ-ын эрсдэлийн удирдлагыг банк, хөрөнгийн зах зээл, даатгал зэрэг санхүүгийн байгууллагуудад нэвтрүүлэх
- Салбарын стандарт, жишиг тогтоох. Жишээ нь, Нэхмэлийн салбарын ногоон зээлийн шалгуур, Жендерийн мэдрэмжтэй санхүүжилт, уур амьсгалын эрсдэлийг тооцох, БОНЗ-ын ил тод байдал, тайлагналын стандарт, БОНЗ-н эрсдэлийг үнэ, зээлийн скорингд тооцох, уур амьсгалын стресс тест хийх
- Дэмжих бодлого: чадавх бэхжүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, татварыг татан төвлөрүүлэх, мэдээллийн сан бий болгох зэрэг

2. Ногоон хөрөнгийн урсгал

- Ногоон санхүүжилтийг дэмжих төсөв, мөнгөний бодлого, зохицуулалт, хөшүүрэг, урамшууллыг бий болгох
- Ногоон эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ногоон бонд зэрэг санхүүгийн хэрэгслүүд нэвтрүүлэх
- Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (МНСК) байгуулах
- Ногоон төслүүд, бүтээгдэхүүн бэлтгэх
- Ногоон худалдан авалт, татвар
- Гадны ногоон хөрөнгө оруулалт
- Ногоон таксономи, статистик, баталгаажуулалт

3. Бодлогын таатай орчин бүрдүүлэх

- Үндэсний тогтвортой санхүүжилтийн оновчтой засаглалыг бий болгох
- Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, чадавхижуулах, гүйцэтгэлд хяналт тавих
- Чадавхи бэхжүүлэх (зохицуулагч байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, их дээд сургуулиуд, төсөл боловсруулагчид)
- Судалгаа
- Хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

www.toc.mn / баримт бичиг, тайлан

ToC
МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ХОЛБОО

Анхаарал хандуулсанд баярлалаа!

toc.mn /toc.mn /tocmn @ToC_Mongolia